



YAKUTSK 2024
Children of Asia
8th International Sports Games

8th CHILDREN OF ASIA INTERNATIONAL SPORTS GAMES

**ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НААДМЫН
ТАЕКВОНДОГИЙН ТӨРЛИЙН СОРИЛ ТЭМЦЭЭН**

2024.04.2-3
ХӨВСГӨЛ АЙМАГ - МӨРӨН ХОТ

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НААДМЫН ТАЕКВОНДОГИЙН ТӨРӨЛД
ЭХ ОРНОО ТӨЛӨӨЛӨН ӨРСӨЛДӨХ ТАМИРЧДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
СОРИЛ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

“Азийн хүүхдүүд 2024” олон улсын хүүхдийн наадмын таеквондогийн төрөлд эх орноо төлөөлөн өрсөлдөх тамирчдыг сонгон шалгаруулах

ХҮҮХДИЙН НААДМЫН ТУХАЙ

VIII дахь удаагийн “Азийн хүүхдүүд 2024” олон улсын хүүхдийн наадам нь ОХУ-ын Бүгд Найрамдах Саха /Якут/ улсын Якутск хотноо 2024 оны 6 сарын 25-ны өдрөөс 2024 оны 7 дугаар сарын 7-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Тус наадмын таеквондогийн төрөл нь хуваарь ёсоор 6 сарын 27, 28-ны өдрүүдэд Elley Botour Ice Palace ордонд зохион байгуулагдана. Монголын таеквондочдоос өмнө нь тус наадамд алт, мөнгө, хүрэл медалиуд хүртэж байсан түүхтэй.

Наадам зохион байгуулагчдын зүгээс наадмын өдрүүдэд Якутск хотод байрлах тамирчдын байр, хоолыг бүрэн хариуцна.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Зохион байгуулагч	Монголын таеквондогийн холбоо
Хамтран зохион байгуулагч	Биеийн тамир, спортын улсын хороо
Холбоо барих утас	7015-5500, 8619-0073
Имэйл	mongoliatekwondo@gmail.com
Нийгмийн сүлжээ	https://www.facebook.com/MongolTaekwondo
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Спортын төв Ордон

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Огноо	Хөтөлбөр	Байршил
2024.3.22 - 27	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
3 сарын 30	Техникийн зөвлөгөөн	Хөвсгөл аймгийн спорт ордон
	Жин үзэлт	
4 сарын 2-3	Тэмцээн	

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.
- ❖ Бүртгэл хаагдсаны дараа оролцогч тамирчдын жин үзүүлэх байршил болон хугацааг олон нийтэд мэдээлнэ. (оролцогч байгууллагуудын бүсчлэл, оролцогчдын тоог харгалзан үзнэ)

ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

1. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Оролцогч тамирчин нь Күккивоны хар бүс, дантай байна.
- Нэг байгууллагаас орох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй.
- Тамирчдын жинг олон кг-р хасахгүй байхыг нийт багш, дасгалжуулагч нарт онцгойлон анхааруулж байна
- Тэмцээнд оролцох тамирчид Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдана



- Тулаан KPNP цахим хамгаалах систем дээр явагдана.
- Шүдний хамгаалалтын хувьд өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэйгөөс бусад өнгөтэй шүдний хамгаалалт зүүхийг хориглоно.
- Шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас /костюм/ өмсөх шаардлагатай.
- KPNP цахим хамгаалалтыг тэмцээн зохион байгуулагч тал хариуцах ба KPNP оймсыг багууд өөрсдөө бэлдэж ирэх.

2. ТУЛААН /ЖИНГИЙН ДАРААЛАЛ/

Эр		Эм	
- 48 кг	45 кг жингээс 48 кг жингийн хооронд	- 44 кг	42 кг жингээс 44 кг жингийн хооронд
- 55 кг	51 кг жингээс 55 кг жингийн хооронд	- 49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
- 63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд	- 55 кг	52 кг жингээс 55 кг жингийн хооронд
- 73 кг	68 кг жингээс 73 кг жингийн хооронд	- 63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд
+ 73 кг	78 кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 63 кг	63 кг жингээс дээш жинтэй тамирчид

- ❖ Жин тус бүрт заасан жиндээ багтаж орох хэрэгтэй ба заасан жингээс 100гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.

3. ТАМИРЧДЫН НАС

Хүүхдийн наадамд 15-16 насны тамирчид (01.01.2008-31.12.2009) оролцох эрхтэй

3. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ

Улаанбаатар хот болон Хөвсгөл аймгийн тамирчид дэвжээний төлбөр 50.000 (тавин мянга) төгрөг,

- Мөрөн хотоос 1000 км дотогш 40.000 (дөчин мянга) төгрөг,
- Мөрөн хотоос 1000 км гадагш 30.000 (гучин мянга) төгрөг

Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

4. ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН ГАРГАХ

Жин тус бүрт түрүүлсэн тамирчин “Азийн хүүхдүүд 2024” олон улсын хүүхдийн наадмын таеквондогийн төрөлд эх орноо төлөөлөн өрсөлдөх эрхийн батламж гардан авах ба мөнгөн медаль хүртсэн тамирчин нөөц тамирчнаар бүргэгдэж нэгдсэн бэлтгэл сургуулилтад хамрагдах эрхтэй болно.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -